



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/129

Улаанбаатар хот

“Менторшип хөтөлбөр”-ийг зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4 дэх заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 07, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Хүүхэд, залуучуудын хөгжил хамгаалал-2028” арга хэмжээ батлах тухай 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх “Менторшип” хөтөлбөрийг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч:	Н.Бямбагэрэл	Засаг даргын орлогч
Гишүүд:	Б.Нацагдорж	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны дарга (зөвшилцсөнөөр)
	Т.Батцэцэг	Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Ц.Цолмонбаатар	Дүүргийн Боловсролын хэлтсийн дарга
	Х.Азбаяр	Дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтсийн дарга
	Б.Болортунгалаг	Дүүргийн “Хүүхэд хөгжлийн цогцолбор” УТҮГ-ын дарга
	Б.Эрдэнэбат	Дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга
	Р.Очирпүрэв	Дүүргийн Биеийн тамир, спорт хорооны дарга
Нарийн бичгийн дарга:	Л.Баярмаа	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

2.Ажлын хэсгийг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилт, үр дүнг танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Н.Бямбагэрэл)-т үүрэг болгосугай.

3.Дээрх үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ